



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР 2018 ОН



Өлгий хот 2019 он

Танилцуулгыг хянан, тохиосон:

Х.Бахыт

Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

Х.Аленхан

Санал хүсэлт байвал доорх
хаягаар холбоо барина уу.

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс
Засаг даргын тамгын газрын байр

Е-mail: bayan-ulgii@nso.mn

Утас: 70422322

Интернет хаяг: [//www.nso.mn/bayan-ulgii.nso.mn/](http://www.nso.mn/bayan-ulgii.nso.mn/)

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс
Өлгий хот, 2019 оны 8-р сар

АГУУЛГА

I.Оршил	3
I.1 Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт	4
I.2 Эдийн засагт ХАА-н салбарын эзлэх байр суурь	7
II. Мал аж ахуй		
II.2.1 Малтай өрх, малчин өрх, малчдын тоо	8
II.2.2 Малчдын соёл, ахуйн үзүүлэлт	9
II.2.3 Малын тоо	10
II.2.4 Малын хэрэглээний зарлага	14
II.2.5 Төл бойжилт	15
II.2.6 Том малын зүй бус хорогдол	17
II.2.7 Иргэдийн хувийн малын бүлэглэлт	18
II.2.8 Бэлтгэсэн хадлан	19
II.2.9 Тариалсан талбай, хураасан ургац	20
Дүгнэлт	21

_____ о О о _____

ОРШИЛ

ХАА-н салбар нь манай улс орны эдийн засгийн баталгаа болж байдаг. Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг.

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуйн, газар тариалангийн салбарын 2017 оны төлөв байдлыг нэгтгэн тусгалаа.

“Монгол Улсын Үндсэн хууль”-нд “Мал сүрэг”-ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн хороо мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогыг 2017 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж, явууллаа.

Энэхүү танилцуулгад малын 2018 оны тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна шинээр гаргасан худаг, уст цэг, малжуулалтын талаархи мэдээллийг тусган орууллаа.

Түүнчлэн уг танилцуулгад газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тариалсан талбай, хураасан ургац, га-гийн ургацын талаарх мэдээллийг жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Салбарын бүтцээр анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүн дотроо мал аж ахуйн салбар 1999 он хүртэл ДНБ-ий 30-40 орчим хувийг үйлдвэрлэж, 2000 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин буурч, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өссөөр байна.

Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэл эдлэл үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болсоор байна.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх. Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр –	1 бод
1 тэмээ	- 1.5 бод
6 хонь	- 1 бод
8 ямаа	- 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ -	5 хонь
1 адуу -	7 хонь
1 үхэр -	6 хонь
1 хонь -	1 хонь
1 ямаа -	0.9 хонь

Богд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ –	4 настай, 5 ба түүнээс дээш настай
Адуу –	3 настай, 4 ба түүнээс дээш настай
Үхэр –	2 настай, 3 ба түүнээс дээш настай
Бог мал –	тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал

Тэмээ-Өмнөх оны төл,	2, 3 настай
Адуу- Өмнөх оны төл,	2 настай
Үхэр- Өмнөх оны төл	

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлэн тооцно.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100–гаар үржүүлэн тооцно.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур -	20-25, Азарга -	12-15, Бух -	35-45,
Хуц, ухна -	25-30		

Том малын зүй бус хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Малын хэрэглээний зарлага.

Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж. Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент. Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс -0.45, Таримал тэжээл -0.35, Даршны ургамал-0.25,

Гар тэжээл, хужир шүү -1.00, Төмс ногооны хаягдал -0.22,

Үр тарианы хаягдал -0.90, Лай -0.40, Сүрэл -0.25

гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ

Малын тэжээлийн ангилал. Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.
 1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
 2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
 3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалсан талбай. Тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Хураасан талбай. Тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Га-гийн ургац. Талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулж тодорхойлно.

Нийт ургац. Тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

ЭДИЙН ЗАСАГТ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ


2018 оны жилийн эцэст 8728 малчин өрх, 13993 малчин, толгойн тоогоор 2 сая 166 мянга 917, бодод шилжүүлснээр 539.3 мянган толгой, үүнээс тэмээ 5649, адуу 95349, үхэр 155914, хонь 979601, ямаа 930404 тоологдсон. Нийт малын 11.9 хувийг бод, 88.1 хувийг бог мал эзэлж байна. Оны эхний төллөх насны хээлтэгчийн 96.0 хувь төллөж, 749.6 мянган төл бойжиж, төл бойжилт 81.9 хувь байна. 71049 толгой том мал зүй бусаар хорогдож, оны эхний малын 3.3 хувийг эзэлж байна. Аймгийн хэмжээнд үр тариа 44.0 тн, төмс 3005.2 тн, хүнсний ногоо 1524.1 тн хураасан нь өнгөрсөн оноос төмс 249.4 тн-оор, хүнсний ногоо 88.2 тн-оор бага байна. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд хөдөө аж ахуйн салбар 33.8 хувийг эзлэж 116.0 тэрбум төгрөг хүрсэн байна.

АЙМГИЙН ДНБ БОЛОН ХАА-Н САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, ЭЗЛЭХ ХУВЬ

/тэрбум төгрөг/

үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018*	2018/2017	
						хувь	зөрүү
Бүгд	289.7	311.0	307.0	329.5	343.3	104.2	13.8
ХАА	113.9	126.6	116.0	116.3	116.0	99.7	-0.3
ДНБ-д эзлэх хувь	39.3	40.7	37.8	33.8	33.8	100.0	

ХАА-Н САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ /тэрбум.төг/



Салбарын бүтцээс үзвэл анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүний дотроо мал аж ахуйн салбар аймгийн ДНБ-ий 33.8 хувийг үйлдвэрлэж, 2006 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-нд эзлэх хувийн жин буурч, үүний оронд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өсөж байна.

Улсын хэмжээнд ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь буурах хандлагатай байна. ХАА-н салбар нь 2001 онд ДНБ-ний 24.9 хувийг эзэлж байсан бол 2015 онд 15 хувийг эзэлж байна. Баруун бүсийн дүнд эзлэх хувь 2001-2007 онд өсөж 74.2-т хүрч 2016 онд 37.8 хувь болон буурсан ч 2017 онд 1.4 хувиар нэмэгдэж 39.2 хувь болсон. Баян-Өлгий аймгийн хувьд хандлага нь баруун бүсийнхтэй ойролцоо байгаа бөгөөд 2004 онд 67.2 хувийг эзэлдэг байсан бол, манай улсын эдийн засгийн цар хүрээ тэлж, үйлчилгээ, аж үйлдвэр, барилгын салбар эрчимтэй хөгжсөнөөр хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь аажмаар буурч 2018 онд 33.8 хувийг эзэлж байна..

МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО, НАСНЫ БҮЛГЭЭР

Сумын нэр	Нийт малчдын тоо	<16	16-34	15-34	35-54 насны эм, 35-59 насны эр	55 ба түүнээс дээш насны эм, 60 ба түүнээс дээш насны эр	Эрэгтэй	Эмэгтэй
Өлгий	8	0	2	2	4	2	6	2
Алтай	966	0	333	333	527	106	622	344
Алтанцөгц	564	0	182	182	333	49	362	202
Баяннуур	623	1	162	163	404	56	407	216
Бугат	486	0	155	155	289	42	336	150
Булган	1 704	1	756	757	786	161	922	782
Буянт	639	0	190	190	360	89	363	276
Дэлүүн	1 689	2	601	603	986	100	956	732
Ногооннуур	1 177	0	461	461	631	85	853	324
Сагсай	900	0	321	321	469	110	705	195
Толбо	895	1	282	283	478	134	638	257
Улаанхус	2 109	1	684	685	1162	262	1232	876
Цэнгэл	2 233	2	842	844	1124	265	1274	959
Дүн	13 993	8	4971	4 979	7553	1461	8676	5315

Аймгийн хэмжээгээр 2018 онд мал тооллогын дүнгээр 8728 малчин өрх, 13993 малчин тоологдсон байна. Үүний 8 16-аас доош насны, 4971 16-34 насны, 7553 35-59 насны, 1461 60-аас дээш насны хүн эзэлж, жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин байна.

МАЛТАЙ, МАЛЧИН ӨРХ, НАСНЫ БҮЛЭГ

Үзүүлэлтүүд	2015	2016	2017	2018
Малтай өрх	14608	15192	14976	14910
Малчин өрх	8872	8888	9261	8728
Малчдын тоо	18398	18411	17200	13993
Үүнээс: 15-34 насны	7396	6927	6515	4979
35-59 насны	9433	9884	8823	7553
Тэтгэврийн насны	1569	1600	1862	1461

МАЛЧДЫН АХУЙ, СОЁЛЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ӨРХИЙН ТООГООР

Үзүүлэлтүүд	2015	2016	2017	2018
Цахилгаантай өрх	7289	5928	5978	6363
Телевизортой	4355	3401	3554	3211
Автомашинтай	3542	5359	2301	3248
Мотоциклтэй	3475	2775	1730	2541
Худагтай	2974	3691	5240	4372

2018 оны тооллогоор нийт малчин өрхийн 72.9 хувь нь цахилгааны эхүүсгүүртэй, 36.8 хувь нь телевизортой, 37.2 хувь нь авто машинтай, 29.1 хувь нь мотоциклтэй, 50.1 хувь нь инженерийн хийцтэй худагтай гэсэн дүн гарлаа.

Сүүлийн жилүүдэд малчин өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг нарны зайн эрчим хүчээр хэрэглээг өрхийн тоо өнөрсөн жилээс буурсан байна. 2008 онд 6.2 мянган өрх цахилгааны эх үүсгүүртэй байсан бол 2009 онд 9.2 мянга болж 1.5 дахин буюу 2.9 мянган өрхөөр нэмэгдсэн байна. Харин 2013 онд энэ үзүүлэлт 6.6 мянга болж 27.8 хувиар багассан нь сүүлийн жилүүдэд төврүү шилжих хөдөлгөөн ихэссэнтэй холбоотой малчин өрхийн тоо багасч улмаар 2018 онд цахилгааны эх үүсгүүртэй өрхийн тоо 6363 болж 6.4 хувиар нэмэгдэж байна. 2018 онд авто машинтай өрхийн тоо 947 өрхөөр буюу 41.1 хувиар, Мотоциклтэй өрхийн тоо 811 өрхөөр буюу 46.9 хувиар тус тус нэмэгдэж байна.

МАЛЧДЫН АХУЙ, СОЁЛЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, СУМААР

Сумын нэр	Худагтай өрх	Авто машинтай		Мотоциклтэй		Гар утастай		Хийсэн эсгий (м)
		өрхийн тоо	Машины тоо	Өрхийн тоо	Мотоциклийн тоо	Өрхийн тоо	Гар утасны тоо	
Алтай	275	245	307	212	212	675	951	1438
Алтанцөгц	165	247	330	187	187	383	683	78
Баяннуур	903	226	265	230	230	454	405	612
Бугат	608	278	370	145	149	424	496	581
Булган	146	386	418	261	265	482	680	358
Буянт	49	268	305	181	181	420	630	119
Дэлүүн	6	830	863	241	241	860	614	825
Ногооннуур	708	731	581	220	220	829	279	157
Сагсай	391	280	460	172	172	693	840	978
Толбо	258	421	448	176	176	586	843	992
Улаанхус	439	742	799	494	496	740	940	1059
Цэнгэл	45	440	428	246	246	862	986	683
Өлгий	1247	293	321	12	12	76	402	0
Дүн	5240	5387	5895	2777	2787	7484	8749	7880

МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, СҮРГИЙН БҮТЭЦ

Малын тоо. 2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 2166.9 мянган толгойд хүрч, өмнөх оныхоос 2.7 хувиар буюу 59232 толгойгоор буурлаа. Үүнд тэмээ 5649 толгой, адуу 95349 толгой, үхэр 155914 толгой, хонь 979601 толгой, ямаа 930404 толгой тус тус тоологдсон.

МАЛЫН ТОО, ТӨРЛӨӨР

Сумын нэр	2018 он					
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Өлгий	24 993	38	1 111	5 500	6 382	11 962
Алтай	154 147	377	9 214	15 423	81 262	47 871
Алтанцөгц	117 471	913	5 347	6 455	44 210	60 546
Баяннуур	164 591	575	6 278	6 761	55 082	95 895
Бугат	113 122	74	4 732	7 520	51 730	49 066
Булган	139 585	663	7 261	12 963	32 010	86 688
Буянт	131 784	219	4 995	9 690	79 765	37 115
Дэлүүн	234 736	326	11 278	20 081	101 804	101 247
Ногооннуур	232 437	574	9 653	12 770	89 909	119 531
Сагсай	159 869	350	8 203	11 679	84 413	55 224
Толбо	174 572	105	6 304	9 928	105 446	52 789
Улаанхус	215 309	781	8 751	18 098	110 605	77 074
Цэнгэл	304 301	654	12 222	19 046	136 983	135 396
Дүн	2 166 917	5 649	95 349	155 914	979 601	930 404

МАЛЫН ТОО, ТӨРЛӨӨР

Үзүүлэлт	2015	2016	2017	2018
Бодоор /мян.тол/	487,6	528,6	548,6	539,3
Толгойн тоо	2021046	2167351	2226149	2166917
Тэмээ	4717	4933	5279	5649
Адуу	77291	85779	93402	95349
Үхэр	144761	155615	161025	155914
Хонь	850620	937710	995222	979601
Ямаа	943657	983314	971221	930404

НИЙТ МАЛЫН ТООНД ХЭЭЛТЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

Үзүүлэлт	2015	2016	2017	2018
Дүн	44.4	42.2	41.1	42.2
Ингэ	29.6	30	30,0	0.2
Гүү	32.7	29.7	29,8	3.2
Үнээ	43.9	38.7	38,8	6.8
Эм хонь	45.6	48.1	43,7	46.3
Эх ямаа	44.4	44.3	42,5	43.5


МАЛЫН ТОО, ТӨРЛӨӨР, СУМААР, БОДОД ШИЛЖҮҮЛСЭН

Сумын нэр	2018 он					
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Өлгий	9 226.9	57.0	1 111.0	5 500.0	1 063.7	1 495.3
Алтай	44 730.0	565.5	9 214.0	15 423.0	13 543.7	5 983.9
Алтанцөгц	28 108.1	1 369.5	5 347.0	6 455.0	7 368.3	7 568.3
Баяннуур	35 068.7	862.5	6 278.0	6 761.0	9 180.3	11 986.9
Бугат	27 117.9	111.0	4 732.0	7 520.0	8 621.7	6 133.3
Булган	37 389.5	994.5	7 261.0	12 963.0	5 335.0	10 836.0
Буянт	32 947.0	328.5	4 995.0	9 690.0	13 294.2	4 639.4
Дэлүүн	61 471.2	489.0	11 278.0	20 081.0	16 967.3	12 655.9
Ногооннуур	53 210.2	861.0	9 653.0	12 770.0	14 984.8	14 941.4
Сагсай	41 378.8	525.0	8 203.0	11 679.0	14 068.8	6 903.0
Толбо	40 562.5	157.5	6 304.0	9 928.0	17 574.3	6 598.6
Улаанхус	56 088.9	1 171.5	8 751.0	18 098.0	18 434.2	9 634.3
Цэнгэл	72 004.0	981.0	12 222.0	19 046.0	22 830.5	16 924.5
Дүн	539 304	8 474	95 349	155 914	163 267	116 301

Улсын хэмжээнд нийт сүрэгт эзлэх хонины тоо толгойн хэмжээ буурах хандлагатай байна. Баян-Өлгий аймгийн нийт мал сүргийн 1991 онд 60.7 хувийг хонь эзэлж байсан бол 1992 оноос буурч 2016 онд 43.2 хувьд хүрчээ. Аймгийн хонины тоо толгойн нийт сүрэгт эзлэх хувь 2001-2016 онд улсын болон баруун бүсийн дүнгээс доогуур түвшинд байна.

Улсын хэмжээнд нийт сүрэгт эзлэх ямааны тоо толгойн хэмжээ 1971-1992 онд тогтвортой байсан бол 1992 оноос огцом өсөх хандлагатай байна. Баян-Өлгий аймгийн нийт сүргийн 1971 онд 26.3 хувийг ямаа эзэлж байсан бол 2016 онд 43.2 хувьд хүрчээ. Ямааны тоо толгойн нийт сүрэгт эзлэх хувь улсын дүнгээс 2.1 пунктээр өндөр байгаа ч баруун бүсийн дүнгээс 2.7 пунктээр бага байна.

ЯМААНЫ ТОО ТОЛГОЙН НИЙТ СҮРЭГТ ЭЗЛЭХ ХУВЬ



Аймгийн малын тооны олон жилийн динамикийг харахад түүний өөрчлөлтөд нийгмийн өөрчлөлтөөс гадна цаг агаарын хүчин зүйл хүчтэй нөлөөлж байна. 1990-ээд оны эхээр мал хувьчилсны дараа малын тооны тодорхой өсөлт гарсан боловч 2001, 2002, 2010 оны өвөл, хаврын зуд малын тоог ихээхэн бууруулсан билээ. Энэ хандлага бүх төрлийн малд ажиглагдсан бөгөөд зудны дараа түргэн өсөлттэй ямаа, хонь хурдан өссөн байна. Ноолуурын үнийн өсөлтөөс шалтгаалан ямаагаа түлхүү өсгөх хандлагатай байна.

ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО

Малын төрөл	2014	2015	2016	2017	2018
Дүн	797053	835766	914198	915932	914738
Ингэ	1453	1384	1482	1571	1695
Гүү	20594	22770	25495	27750	29412
Үнээ	51023	55884	60269	62282	62096
Эм хонь	349634	364523	409189	420942	423590
Эх ямаа	374349	391205	417763	403387	397945

Хээлтэгч мал нь нийт малын 41.1 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 30.0 хувь, адуун сүргийн 29.8 хувь, үхэр сүргийн 38.8 хувь, хонин сүргийн 43.7 хувь, ямаан сүргийн 42.5 хувийг тус тус эзэлж байна.

Мал аж ахуйн эрдэмтэн судлаачдын үзэж байгаагаар мал аж ахуйн нөхөн үйлдвэрлэлийг хэвийн хэмжээнд байлгахад хээлтэгч мал бод малын хувьд сүргийн 50 – 55 хувь, бог малын хувьд сүргийн 60 – 65 хувийг эзэлж байвал зохимжтой байна гэж үздэг бөгөөд сүүлийн жилүүдэд энэ харьцаа алдагдаж, сүүлийн 5 жилийн байдлаар хээлтэгч малын эзлэх хувь бод малд дунджаар 35.3 хувь, бог малд 42,1 хувь байна.

НИЙТ МАЛЫН ТООНД ХЭЭЛТЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

Үзүүлэлт	2015	2016	2017	2018
Дүн	44.4	42.2	41.1	42.2
Ингэ	29.6	30	30,0	0.2
Гүү	32.7	29.7	29,8	3.2
Үнээ	43.9	38.7	38,8	6.8
Эм хонь	45.6	48.1	43,7	46.3
Эх ямаа	44.4	44.3	42,5	43.5

ТӨЛ ӨГӨӨГҮЙ ХЭЭЛ ХАЯСАН ХЭЭЛТЭГЧ

Төрөл	2015	2016	2017	2018
Дүн	4369	23945	12137	46647
Ингэ	2	8	2	7
Гүү	162	716	381	2140
Үнээ	238	734	598	1374
Эм хонь	1384	3995	1936	6805
Эм ямаа	2583	18492	9220	36321

2018 онд оны эхний төллөх насны хээлтэгчийн 5.1 хувь буюу 46647 толгой мал хээл хаясаны улмаас төл өгөөгүй байна. Хээл хаясан малын тоо 2017 оныхоос 34510 толгойгоор буюу 3.8 дахин өссөн байна.

СУВАЙРСАН ХЭЭЛТЭГЧ

Төрөл	2015	2016	2017	2018
Дүн	10304	18095	14706	38948
Ингэ	34	85	43	40
Гүү	817	1255	1450	2459
Үнээ	1720	2517	2811	4496
Эм хонь	3454	5946	4647	18431
Эм ямаа	4279	8292	5755	13522

ХЭЭЛТҮҮЛЭГЧ МАЛЫН ТОО

Төрөл	2015	2016	2017	2018
Буур	77	87	93	114
Азарга	2233	2512	2762	2840
Бух	2874	2992	3031	2761
Хуц	7695	8401	9002	8380
Ухна	8386	8955	8488	8120
Дүн	21265	22947	23376	22215


2018 онд 22215 толгой хээлтүүлэгч мал тоологдож 2017 оныхоос 4.9 хувиар буюу 1161 толгойгоор буурсан байна.

НЭГ ХЭЭЛТҮҮЛЭГЧИД НОГДОХ ХЭЭЛТЭГЧИЙН ТОО

Төрөл	үржлийн норм	2015	2016	2017	2018
Ингэ	20-25	18	17	16	15
Гүү	12-15	10	10	9	10
Үнээ	35-45	19	20	20	22
Эм хонь	25-30	47	49	45	49
Эм ямаа	25-30	47	47	49	41

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь бод малын хувьд үржлийн нормоор, харин бог малын хувьд алдагдсан хэвээр байна. Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох 49 эм хонь, эм ямаа 41 ногдож өндөр үзүүлэлт гарч байна.

МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГЫН БҮТЭЦ /хувиар/



2018 онд оны эхний малын 37.0 хувьтай тэнцэх 823752 толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна. Үүнээс 25.8 хувийг хүнсэнд, 56.1 орчим хувийг зах зээлд худалдан борлуулж, 17.8 хувийг шилжүүлж, 0.3 хувь буюу 2712 толгой мал хулгайд алдагдсан.

МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА

Сумын нэр	Зах зээлд худалдаж, борлуулсан	Шилжүүлсэн	Алдсан, хулгайлагдсан, олдохгүй байгаа	Хүнсэнд хэрэглэсэн
Өлгий	5622	3327	23	2882
Алтай	31610	12294	116	14334
Алтанцөгц	21779	7906	143	10408

Баяннуур	32309	16379	819	14588
Бугат	23962	13186	72	12184
Булган	20911	6719	117	14131
Буянт	25275	6917	49	8898
Дэлүүн	65309	24576	886	24247
Ногооннуур	39918	10299	67	29104
Сагсай	31103	7057	148	16235
Толбо	42015	11346	97	15218
Улаанхус	48326	9848	127	23035
Цэнгэл	73862	16376	48	27545
Дүн	462001	146230	2712	212809

Төл бойжилт

2018 оны байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 94.9 хувь буюу 868091 толгой эх мал төллөж гарсан төлийн 86.4 хувь буюу 749643 толгой төл бойжуулав.

ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ

Сумын нэр	Бүгд	Төллөсөн хээлтэгч				
		Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа
Алтай	67194	137	2992	6415	36558	21092
Алтанцөгц	52660	415	1756	2695	20287	27507
Баяннуур	72550	169	1816	2650	24532	43383
Бугат	49166	31	1565	2927	22838	21805
Булган	58504	218	2369	5565	14374	35978
Буянт	65331	81	1856	4450	39590	19354
Дэлүүн	105481	104	3896	8435	47072	45974
Ногооннуур	79518	112	2090	3676	32847	40793
Сагсай	77036	70	2811	4989	41142	28024
Толбо	66460	26	1857	3441	40222	20914
Улаанхус	88522	204	2683	6903	46341	32391
Цэнгэл	119696	114	3305	7244	54465	54568
Өлгий	12620	14	416	2706	3322	6162
Дүн	914738	1011	24216	57604	407406	412717

БОЙЖУУЛСАН ТӨЛ

Сумын нэр	Бүгд	Бойжсон төл				
		Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Алтай	60732	61	2471	5963	34514	17723

Алтанцөгц	37853	210	1239	1982	15055	19367
Баяннуур	56699	83	1174	2143	20190	33109
Бугат	37775	14	1209	2355	18012	16185
Булган	53853	104	1881	4740	14246	32882
Буянт	30226	28	714	2821	19242	7421
Дэлүүн	87468	69	2851	7472	40861	36215
Ногооннуур	78503	122	2202	3690	31016	41473
Сагсай	52138	46	2044	4519	30324	15205
Толбо	55968	11	979	3034	36040	15904
Улаанхус	78508	165	2411	6553	41839	27540
Цэнгэл	107613	78	2567	6175	52738	46055
Өлгий	12307	11	384	2643	3291	5978
Дүн	749643	1002	22126	54090	357368	315057

БОЙЖУУЛСАН ТӨЛ, ОЛОН ЖИЛЭЭР

Он	Бүгд	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
1997	532687	862	16167	38279	288883	188496
1998	390894	638	9988	29507	217656	133105
1999	528661	818	14510	36919	281421	194993
2000	432093	619	10377	30271	232228	158598
2001	464662	624	12163	28100	238312	185463
2002	336929	567	8420	23093	178912	125937
2003	515438	613	12776	29938	236176	235935
2004	524505	547	11917	29467	232859	249715
2005	410257	473	9664	24541	203799	171780
2006	521900	508	12240	28166	231710	249076
2007	539265	443	12402	28270	240525	257625
2008	484506	424	9729	23705	234999	215649
2009	413901	487	8656	22460	207360	174938
2010	357520	420	6726	19061	181318	149995
2011	487580	615	11036	26655	204194	245080
2012	489680	642	12575	26600	217323	232540
2013	607272	665	13553	34455	255534	303065
2014	664384	613	15785	41846	288752	317388
2015	781029	726	19625	49506	345737	365435
2016	789819	700	20563	52439	353164	362953
2017	856849	964	23373	56034	394647	381831
2018	749643	1002	22126	54090	357368	315057
%	87.5	103.9	94.7	96.5	90.6	82.5
Зөрүү	-107206	38	-1247	-1944	-37279	-66774

Бойжуулсан төл өмнөх оныхтой харьцуулахад ботгоос бусад төлийн төрөл дээр 1247-66774 толгой хүртэл буурсаныг дээрхи хүснэгтээс харж болно.

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

2018 онд оны эхний нийт малын 3.3 хувьтай тэнцэх буюу 71049 толгой мал хорогдсон нь 2017 оныхоос 53249 толгойгоор буюу 4.0 орчим дахин их байна. Нийт хорогдсон малын 46,3 хувийг ямаа, 38.9 хувийг хонь, 10.5 хувийг үхэр, 4.1 хувийг адуу, 0.07 хувийг тэмээ эзэлнэ.Өвчнөөр 3151 толгой мал хорогдсон нь нийт хорогдлын 4.4 хувийг эзэлж байна.

Сумын нэр	Хорогдсон том мал, бүгд			
	2015	2016	2017	2018
Алтай	488	2663	761	5669
Алтанцөгц	379	936	577	2717
Баяннуур	700	2267	533	14325
Бугат	185	288	149	2249
Булган	517	1544	9409	1085
Буянт	293	450	729	13057
Дэлүүн	685	963	887	11214
Ногооннуур	503	1071	331	1653
Сагсай	538	1721	1930	8741
Толбо	94	526	543	2554
Улаанхус	324	549	366	4091
Цэнгэл	566	17489	1274	2457
Өлгий	247	386	311	1237
Дүн	5519	30853	17800	71049

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

Малын төрөл	2014	2015	2016	2017	2018
Бүгд	5164	5519	30873	17800	71049
Тэмээ	32	35	55	34	54
Адуу	412	440	1338	800	2896
Үхэр	615	735	3167	1718	7491
Хонь	1617	1808	10260	4594	27696
Ямаа	2488	2501	16053	10654	32912

ОНЫ ЭХНИЙ МАЛД ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ

Малын төрөл	2014	2015	2016	2017	2018
Бүгд	0.3	0.3	1.5	0.8	3.3
Тэмээ	0.7	0.7	1.1	0.7	1.0
Адуу	0.7	0.6	1.8	0.9	3.0
Үхэр	0.6	0.6	2.2	1.1	4.8
Хонь	0.2	0.2	1.2	0.5	2.8
Ямаа	0.3	0.3	1.8	1.1	3.5

ИРГЭДИЙН ХУВИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ

Үзүүлэлтүүд	Малтай өрхийн тоо			Малын тоо		
	2016	2017	2018	2016	2017	2018
10 хүртэл малтай	2 045	2 042	2 077	9 289	9 029	9 199
11-30 малтай	1 743	1 793	1 868	35 122	36 045	37 024
31-50 малтай	1 326	1 300	1 331	53 221	51 913	53 310
51-100 малтай	2 309	2 235	2 233	169 627	166 129	166 844
101-200 малтай	4 013	3 965	3 948	584 425	579 083	574 004
201-500 малтай	2 980	3 044	2 905	871 730	890 528	854 098
501-999 малтай	448	489	427	289 818	320 485	283 756
1000-1499 малтай	57	61	77	67 754	71 375	92 112
1500-2000 малтай	18	24	22	31 500	40 297	37 699
2000 дээш малтай	22	23	22	51 412	58 276	55 724
Дүн	14961	14976	14 910	2163898	2223160	2 163 770

НЭГ ӨРХӨД НОГДОХ ХУВИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ

Үзүүлэлтүүд	Өрхийн тоо	Бүгд	Үүнээс:				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
10 хүртэл малтай	2 077	9 199	4	535	5 802	768	2 090
11-30 малтай	1 868	37 024	32	2 157	6 144	10 220	18 471
31-50 малтай	1 331	53 310	109	2 850	5 974	18 635	25 742
51-100 малтай	2 233	166 844	251	8 729	15 687	64 944	77 233
101-200 малтай	3 948	574 004	1 013	24 939	41 439	242 263	264 350
201-500 малтай	2 905	854 098	2 417	35 408	53 174	390 908	372 191
501-999 малтай	427	283 756	1 093	12 281	17 386	144 097	108 899
1000-1499 малтай	77	92 112	295	3 873	5 592	50 677	31 675
1500-2000 малтай	22	37 699	250	1 815	2 194	23 672	9 768
2000 дээш малтай	22	55 724	185	1 846	2 440	31 937	19 316

Мал бүхий 14608 өрхийг малын тоогоор нь бүлэглэн авч үзвэл, 13.7 хувь буюу 2006 өрх нь 10 хүртэл малтай; 11.7 хувь нь буюу 1706 өрх нь 11-30 малтай; 9.4 хувь буюу 1370 нь 31-50 малтай; 16.3 хувь буюу 2375 нь 51-100 малтай; 27 хувь буюу 3939 нь 101-200 малтай; 18.9 хувь буюу 2760 нь 201-500 малтай; 2.5 хувь буюу 370 нь 501- 999 малтай; 0.3 хувь буюу 44 нь 1000-1499; 0.2 хувь буюу 25 нь 1500-2000 малтай; 0.1 хувь буюу 13 өрх 2000 аас дээш малтай өрх байна.

Мөн 2018 онд нийт малтай өрхөд 101-200 хүртэлх толгой малтай өрхийн эзлэх хувийн жин өмнөх оныхоос 0.9-0,4 пунктээр нэмэгдэж, 501-999 хүртэл малтай өрхийн эзлэх хувийн жин 0-0.3 пунктээр, 1500-2000 малтай өрх 0.1

пунктээр нэмэгдэж 1000-1499 малтай, 2000-аас дээш малтай өрхийн эзлэх хувийн жин өмнөх оныхоос 0,1 пунктээр нэмэгдсэн байна.

БЭЛТГЭСЭН ХАДЛАН

Сумын нэр	2015	2016	2017	2018
Алтай	5320.0	3817.0	5514.0	5596.0
Алтанцөгц	3510.0	5500.0	3040.0	3854.0
Баяннуур	5700.0	3729.0	5897.0	6357.5
Бугат	2250.0	6000.0	2563.0	1512.0
Булган	3800.0	2711.0	4046.8	4289.5
Буянт	2380.0	3902.0	1766.0	1849.3
Дэлүүн	2413.0	2522.5	2593.0	3347.4
Ногооннуур	13175.0	3010.1	11963.8	15590.0
Сагсай	4014.0	16257.8	4117.0	4257.0
Толбо	3000.0	5566.0	2597.0	2799.6
Улаанхус	3300.0	3134.0	3935.8	4278.1
Цэнгэл	7970.0	4445.0	6730.9	8443.0
Өлгий	2400.0	6827.0	2293.6	1919.7
Дүн	59232.0	67421.0	57059.0	64093.1

БЭЛТГЭСЭН ӨВС, ТЭЖЭЭЛ

Үзүүлэлт	2015	2016	2017	2018
Бүгд	60301.0	68824.0	57615.0	64101.6
Байгалийн хадлан	59232.0	67422.0	57059.0	64093.1
Таримал тэжээл	1069.0	1401.6	556.0	8.5

Бэлтгэсэн хадлан, таримал тэжээлийг нэр төрлөөр өмнөх оныхтой харьцуулан авч үзвэл бэлтгэсэн байгалийн хадлан 12.3 хувь буюу 7034.1 тонноор, таримал тэжээл 547.5 тонноор багассан байна.

Тариалсан талбай

Баян-Өлгий аймагт 1990 онд 5.1 мянган га талбайд тариалан эрхэлж байсан бол 2018 онд 19.0 мянган га талбай болж өссөн байна. Нийт талбайн 62.9 хувь буюу 1197.4 га талбайд малын тэжээлийн ургамал, 19.2 хувь буюу 365.9 га талбайд төмс, 15.6 хувь буюу 296.1 га-д хүнсний ногоо, 2.2 хувь буюу 42.0 га талбайд үр тариа тариалжээ. Энэ нь өнгөрсөн оныхоос үр тариа 16.5 га-гаар, хүнсний ногоо 134.6 га-гаар, 763.2 га-гаар нэмэгдэж, харин төмс 119.2 га-гаар өмнөх оноос буурсан байна.

ТАРИАЛСАН ТАЛБАЙ /га/

Үзүүлэлт	2015	2016	2017	2018
Нийт тариалсан талбай:	907.7	885.4	1106.3	1901.4
Үр тариа	47.5	45.5	25.5	42.0
Төмс	282.0	262.0	485.1	365.9
Хүнсний ногоо	123.0	123.0	161.5	296.1
Тэжээлийн ургамал	455.0	455.0	434.2	1197.4

Хураасан ургац

Баян-Өлгий аймаг 1990 онд 80.0 мян.т тэжээлийн ургамал, 6.3 мян.т төмс, 1.5 мян.т хүнсний ногоо, 14.1 тонн үр тариа хурааж байсан бол 2017 онд 32.5 мян.т төмс, 16.1 мян.т хүнсний ногоо, 7.9 мян.т тэжээлийн ургамал, 4.6 тн үр тариа хураан авчээ.

2018 онд хураасан ургац 2017 оныхоос үр тариа 2.1 тонн буюу 4.6 хувиар, төмс 249.4 тонн буюу 7.7 хувиар, хүнсний ногоо 88.2 тонн буюу 5.5 хувиар, тэжээлийн ургамал 13.6 тонн буюу 1.7 хувиар тус тус буурсан байна.

ХУРААСАН УРГАЦ /тн/

Үзүүлэлт	2015	2016	2017	2018
Үр тариа	56.9	56.0	46.1	44.0
Төмс	2756.0	2728.0	3254.6	3005.2
Хүнсний ногоо	1118.0	1137.0	1612.3	1524.1
Тэжээлийн ургамал	1069.0	1402.0	792.1	778.5

Хөдөө аж ахуйн эдэлбэр газар

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэдээгээр 2018 онд хөдөө аж ахуйн эдэлбэр газрын хэмжээ 3509.7 мянган га байна. Үүний 99.6 хувийг бэлчээрийн талбай, 0.3 хувийг хадлангийн талбай, 0.03 хувийг тариалангийн талбай, 0.01 хувийг атаршсан газар, 0.02 хувийг бусад хэрэгцээний газар эзэлж ба

ХӨДӨӨ АЖ АХУЙН ЭДЭЛБЭР ГАЗАР, ГА-ГААР

Сумын нэр	ХАА-н эдэлбэр газар Бүгд	Үүнээс:				
		Бэлчээрийн газар	Хадлангийн талбай	Тариалангийн газар	Атаршсан газар	бусад хэрэгцээн ий газар
Алтай	269951.5	268824.5	1000.0	69.9		57.1
Алтанцөгц	164481.0	161667.0	2400.0	156.0	223.1	34.9
Баяннуур	159164.0	158293.9	400.0	294.5	114.5	61.1
Бугат	199373.0	198740.0	555.0	24.9	4.1	49.0
Булган	461879.3	461348.7	364.3	99.1		67.2
Буянт	181669.0	181403.1	180.0	22.2	24.4	39.2
Дэлүүн	496165.8	495534.6	524.0	9.0		98.2
Ногооннуур	395953.6	392438.6	3382.0	33.3	66.7	33.0
Сагсай	168402.0	167833.5	400.0	27.1	80.7	60.7
Толбо	283134.0	282684.3	360.0	40.0		49.7
Улаанхус	465310.9	464072.9	1120.0	26.8		91.2
Цэнгэл Өлгий	264212.0	262932.5	816.0	333.5		130.0
Дүн	3509696.1	3495773.6	11501.3	1136.3	513.5	771.3

ДҮГНЭЛТ

2018 онд өвөлжилт хүндхэн, зуд зутархан болж мал аж ахуйн голлох үйлдвэрлэл болох бойжуулсан төлийн тоо хувьд оны эхний төллөх насны хээлтэгч малын 96.0 хувь төллөж, 749.6 мянган төл бойжиж, төл бойжилт 81.9 хувь байна. 71049 толгой том мал зүй бусаар хорогдож, оны эхний малын 3.3 хувийг эзэлж байна. Жилийн эцэст 8728 малчин өрх, 13993 малчин, толгойн тоогоор 2 сая 166 мянга 917, бодод шилжүүлснээр 539.3 мянган толгой, үүнээс тэмээ 5649, адуу 95349, үхэр 155914, хонь 979601, ямаа 930404 тоологдсон. Нийт малын 11.9 хувийг бод, 88.1 хувийг бог мал эзэлж байна.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний 80 гаруй хувийн үйлдвэрлэж, хүн амаа хүнс, өргөн хэрэглээний бараагаар хангах эх үүсвэр болж байгаа бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг бүсчилэн хөгжүүлж, дотоод зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн чанар сайтай, аюулгүй түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх, экспортын нөөцийг нэмэгдүүлэхэд мал аж ахуйн бодлого чухал ач холбогдолтой. 2018 онд тариалсан талбайг ургамлын нэр төрлөөр авч үзвэл үр тариа 44.0 тн, төмс 3005.2 тн, хүнсний ногоо 1524.1 тн хураасан нь өнгөрсөн оноос төмс 249.4 тн-оор, хүнсний ногоо 88.2 тн-оор бага байна.

Газар тариалангийн үйл ажиллагаанд байгаль, цаг уур ихээхэн нөлөөлж байгаа боловч цаашид ургац хураалтын хэмжээг боломжийн хэмжээнд байлгахын тулд га-гийн ургацыг нэмэгдүүлэх, үүний тулд чанартай сайн уринш боловсруулалтыг нэмэгдүүлэх, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх, ургац боловсролтын үед хортон шавьжтай тэмцэх, иргэдийн дунд тариалалт хийх, ургац хураах зэрэг асуудлаар сургалт, сурталчилгаа явуулж мэдлэгийн дээшлүүлэх зэрэгт ихээхэн анхаарах шаардлагатай байна.

Баян-Өлгий аймагт мах, ноосны чиглэлийн казахын ууцан сүүлт керей үүлдрийн хонь, ноолуурын чиглэлийн уулын бор хэмээх үүлдрийн ямаа зэрэг өндөр ашиг шимтэй үүлдрийн болон нутгийн шилдэг омог хэвшлийн мал сүргийг өсгөн үржүүлдэг.

Нутгийн шилдэг омог, үүлдрийн малыг өсгөн үржүүлж, хүрээг нь өргөжүүлэх, малын омог, үүлдэрлэг байдлыг сайжруулах замаар ашиг шимийг нь дээшлүүлэх явдал аймаг, сум, багийн түвшинд бодлого боловсруулагчдын өмнө эрхэм чухал зорилт болгон дэвшүүлэгдэх ёстой.

Нутгийн шилдэг омог, үүлдрийн цөм сүрэг, гадаадын арвин ашиг шимт мал, амьтны шалгарсан удмыг сайжруулагчаар ашиглах, биотехнологи, генийн инженерчлэлийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх замаар малын үүлдэрлэг байдлыг сайжруулах.

Мал сүргийг эрүүлжүүлэх, халдварт, паразиттах өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг олон улсын жишигт хүргэж үр дүнг сайжруулах.

Инженерийн болон энгийн уурхайн худаг, уст цэгийг нэмэгдүүлэх, эзэмшил, ашиглалтыг сайжруулахын зэрэгцээ усны нөөцийн бусад эх үүсвэрийг зохистой ашиглах замаар хүн ам, малын усны хангамжийг нэмэгдүүлэх, уст цэгүүдийг сэргээн засварлах, шинээр гаргах, цас, борооны усыг хуримтлуулан хиймэл нуур, усан сан, хөв, цөөрөм, бий болгох замаар бэлчээрийн усан хангамжийг сайжруулах.

Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар багтаамж, даацыг нэмэгдүүлэх.

Бэлчээрийн даацад тохируулан малын тоо толгойг өсгөн үржүүлэх бодлого хэрэгжүүлэх, ялангуяа манай аймгийн нийт малын 50-аад хувийн эзэлдэг ямаан сүргийн тоо, толгойн өсөлтийг хязгаарлах, бог малын хувьд өсгөж үржүүлж ирсэн уламжлалт харьцаа 75:25 хувь буюу 3 хонь, 1 ямаа гэсэн харьцаагаар өсгөж үржүүлэхэд татварын бодлогоор зохицуулах нь зүйтэй.

МАН-н салбарын хөгжлийн уг язгуур нь сайн үүлдрийн мал үржүүлэх, эрчимжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гэхээсээ бэлчээрийг эзэмших ашиглах, өмчлөх эрх зүйн тогтолцоо гэдгийг онцолж байна.

АШИГЛАСАН НОМ, МАТЕРИАЛ

- 1.Баян-Өлгий аймгийн Статистикийн эмхтгэл , 2010-2018 он
- 2.Монгол улсын статистикийн эмхтгэл 2010-2018 он
- 3.Монгол улсын Хөдөө аж ахуй 1971-1995 онд /статистикийн эмхтгэл/
- 5.Хөдөө аж ахуйн салбар, 2011он, ҮСХороо
- 6.Аймгийн эдийн засаг, нийгмийн байдлын танилцуулга-2010-2017 он,
- 7.Баян-Өлгий аймгийн хөдөө аж ахуйн салбар, 2012-2016 он
- 8.Хөдөө аж ахуйн 2011 оны улсын анх дугаар тооллого, 2012 он
- 9.Статистикийн бюллетень 2018/12 сар, ҮСХороо
- 10.Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn
- 11.Баян-Өлгий аймгийн 2018 оны Мал тооллогын дүн

_____ о О о _____